УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ
1925

# УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

| № | Үйл ажиллагаа | Хугацаа /Улирал/ | | | | Хариуцах эзэн | Хамтрагч байгууллага, нэгж | Үр дүн | Шаардлагатай төсөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | I | II | III | IV | | | | |
| **I.** | **Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах** | | | | | | | | |
| 1.1 | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ 2019.09.04 406 тоот тушаалыг нийт ажилтан, суралцагч нар, үйлчлүүлэгчид таниулан сурталчлах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ Захиргаа, хүний нөөцийн алба | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм мэдээллийн самбарт байршуулах, нэгжүүдэд тараах материал, гарын авлагаар таниулан сурталчилж мэдлэг эзэмшүүлсэн байна. | 1. Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль, Эмнэлгийн мэргэжилтэний ёсзүйн дүрэм, холбогдох журмуудыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн гадаад сайт – Ил тод булан – Ёсзүйн салбар хороо цэсэнд холбогдох байршуулан ажиллаж байна. http://unte.moh.gov.mn/  Зураг. УНТЭ гадаад сайт – ил тод булан – Ёсзүйн хороо цэс |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2. Мөн Ёсзүйн салбар хорооны 120*180 хэмжээтэй, санал хүсэлтийн хайрцагтай 2 мэдээллийн самбарны<br>✓ Ёсзүйн үйл ажиллагаа<br>✓ Авлигын эсрэг үйл ажиллагаа<br>✓ Хууль эрхзүй<br>✓ Зөвлөмж<br>✓ Сургалт<br>✓ Мэдээлэл<br>✓ Зарлал буланд тухай бүрт мэдээ, мэдээллийг байршуулан ажилтан болон үйлчлүүлэгчийг мэдээллэр хангах нөхцлийг бүрдүүлэн, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг гүйцэтгэж байна.<br><br><br>Зураг. Өргөтгөлийн байрны 1-р давхарт байршуулсан самбар<br><br>3. УНТЭ-ийн нийт ажилтнуудад албаны цахим шуудангаар 2025.03.14-ний өдөр Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тушаалаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, "Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйн эрх, үүрэг"-ийг хүргүүлсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж нэгж бүр хэвтэн эмчлүүлэгчийн өрөө, харьяа амбулаторийн кабинетууд, мэдээллийн самбар дээрээ "Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйн эрх, үүрэг"- |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ийг ил тод байршуулах үүргийг хүргүүлж ажилласан.<br><br>Зураг. Нийт ажилтнуудад хүргүүлсэн хичээлийн мэдээлэл<br><br>4. УНТЭ-ийн нийт ажилтнуудад 2025.04.24-ний өдөр ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2025.04.07-ны өдрийн 25/01 дугаар тогтоолоор УНТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны даргаар Ерөнхий мэс заслын тасгийн их эмч Б.Ганзоригийг, орлогч даргаар Эмнэлзүйн албаны дарга Л.Ундармааг, гишүүнээр ЭШСТ-ийн дарга Б.Бат-Ирээдүйг тус тус томилж хорооны бүтцэд өөрчлөлт оруулсанг мэдээллэсэн. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2025.04.07 дугаар 25/01<br><br>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн<br>салбар хорооны бүтцэд өөрчлөлт<br>оруулах тухай<br><br>Эрүүл мэндийн тухай хуулийн 28.1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дүрмийн 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:<br><br>1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга Б.Бат-Ирээдүй тус хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул чөлөөлж, тус салбар хорооны гишүүнээр, тус салбар хорооны орлогч дарга, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий мэс заслын тасгийн их эмч Б.Ганзоригийг тус салбар хорооны орлогч даргын үүрэгт ажлаас чөлөөлж, салбар хорооны даргаар, салбар хорооны гишүүн, тус эмнэлгийн Эмнэлзүйн зохицуулалтын албаны дарга Л.Үндармааг салбар хорооны гишүүнээс чөлөөлж, салбар хорооны орлогч даргаар 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн тус тус томилон ажиллуулсугай.<br><br>2. Салбар хороонд орсон өөрчлөлтийг мэдээний санд бүртгэхийг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.<br><br>ДАРГА Д.ОЮУНБИЛЭГ<br><br>Зураг. ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний<br>ёс зүйн хяналтын хорооны 2025.04.07-ны 25/01 тогтоол<br><br>5. Нийт ажилтнуудад албан цахим шуудангаар Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тоот тушаалаар баталсан "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-ийг хичээл болгон 23 хуудас повер пойнт мэдээллийг уншиж танилцах болон сургалтын үйл ажиллагаанд ашиглуулах зорилгоор хүргүүлсэн болно.<br><br>Зураг. Нийт ажилтнуудад хүргүүлсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хичээлийн мэдээлэл |
| 1.2 | Ёс зүйн дэд хороог байгуулах ажилд хамтран оролцох | + | | | | ЁСЗХ | УНТЭ Захиргаа, хүний нөөцийн алба | Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Ёс зүйн дэд хороо байгуулагдсан байна. | Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн 2024.12.06-ны өдрийн 7/5163 албан бичиг УНТЭ-ийн дэргэд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон Ёс зүйн дэд хороог тусад нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгуулж ажиллах шийдвэр ирсэн. Уг шийдвэрийн дагуу эмнэлгийн ерөнхий захирлын 2025.01.15-ны өдрийн А/11 тушаалаар "УНТЭ-ийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг 5 ажилтны бүрэлдэхүүнтэй байгуулсан. Сонгон шалгаруулалт ил тод, нээлттэй зохион байгуулагдаж 7 гишүүн сонгогдсон. Байгууллагын ерөнхий захирлын 2025.03.27-ны өдрий А/95 тушаалаар эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг баталж, 5 жилийн хугацаатай томилсон. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн:<br>Ёс зүйн дэд хорооны дарга: П.Анхтуяа, Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны албаны дарга<br>Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга: С.Хулан, Захиргаа, хүний нөөцийн албаны Бичиг хэргийн эрхлэгч<br>Ёс зүйн дэд хорооны гишүүд: эмнэлгийн хуулийн зөвлөх Ш.Нарантуяа,<br>Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасгийн зөвлөх эмч Д.Чулуунбаатар,<br>Бөөрний төвийн зөвлөх эмч Д.Чулуунцэцэг,<br>Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төвийн их эмч Э.Элбэгжаргал,<br>Эрүү нүүрний мэс заслын тасгийн ахлах сувилагч Г.Батзаяа |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | <br>УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН<br>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ<br>2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар А/95<br>Эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай<br>Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4, Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 3 дугаар зүйлийн 3.2.7, эмнэлгийн Ерөнхий захирлын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/52 дугаар тушаал, эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хүсэлт, Ёс зүйн дэд хорооны 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:<br>1.Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаатай томилон ажиллуулсугай.<br>2.Байгууллагын ажилтнуудыг ёс зүйн алдаа, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг багасгах/гадагшруулах ажлыг тогтмол зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хууль, журмын дагуу тайлагнаж мэдээлж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (П.Анхтуяа)-д үүрэг болгосугай.<br>3.Эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг нийт ажилтнуудад танилцуулах, танилцуулах ажлыг Захиргаа, хүний нөөцийн алба (П.Мөнхтуул)-нд даалгасугай.<br>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ<br>ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.БЯМБАСҮРЭН<br>141250550<br><br>Зураг. УНТЭ-ийн ерөнхий захирлын 2025.03.27-ны өдрий А/95 тушаалын нүүр<br><br>УНТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Ёс зүйн дэд хороо 2025.05.01-ний өдөр хамтарсан хуралдааныг хийж 2 хорооны хийж гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг тохиролцож, хамтран ажиллах саналыг солилцсон болно. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |   Зураг. Хамтарсан хурлын зураг |
| 1.3 | Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль болон ухааны эрхзүйн баримт бичгүүдийг таниулан, сурталчлах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ Захиргаа, хүний нөөцийн алба | Нийт ажилтанд хуулийн болон анагаах ухааны эрхзүйн баримт бичгийг мэдээллийн самбарт байршуулах, нэгжүүдэд тараах материал, гарын авлагаар таниулан сурталчилж мэдлэг эзэмшүүлсэн | УНТЭ-ийн Захиргаа, Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороо хамтран 2025.01.22-ны өдөр (лхагва гариг) өглөөний 08.00 цагийн нийт эмч нарын яриан дээр Хүний эрхийн үндэсний комиссын ахлах мэргэжилтэн, Хууль зүйн ухааны доктор, Цагдаагийн хурандаа Д.Нямдорж “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | <br><br><br>Зураг. Сургалтын явц |
| 1.4 | Ёсзүй болон анагаах ухааны эрхзүй, үйлчилгээний стандарт зэрэг шаардлагатай ном, стандартуудыг худалдан авч номын санд байршуулах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба | Ёсзүй, эрхзүйн, стандартыг ажилтан уншиж танилцах боломж, нөхцлийг бүрдүүлсэн байна. | Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн комисс, Жендерийн үндэсний хороо зэрэг байгууллагуудын мэдлэг олгох тараах материал, брошурыг үйлчлүүлэгчид болон нэгжийн ажилтнуудад тараасан болно. |
| 1.5 | Ёсзүйн болон анагаах ухааны эрхзүй, үйлчилгээний стандартын мэдлэг олгох гарын авлага, тараах материалыг хэвлүүлэх, шаардлагатай | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ Дотоод хяналтын мэргэжилтэн | Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх таниулан сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулсан байна | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны албаны Уншлагын танхимд<br>- Анагаах ухааны эрх зүйн үндэс ном<br>- Анагаах ухааны ёс зүй номууд ашиглагдаж байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгжүүдэд таниулан байршуулах | | | | | | | | <br><br>Зураг. Номын нүүр<br><br><br>Зураг. Номын нүүр |
| 1.6 | Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёсзүйн хэм хэмжээг сурталчлах, таниулах хөл (анонс) самбаруудыг худалдан авах, нийтийн эзэмшлийн талбайд байршуулах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ Дотоод хяналтын мэргэжилтэн | Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх таниулан сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулсан байна | Амбулаторийн болон эрүүл мэндийн даатгалын өвчний түүх нээгдэх хэсэг, Эрүүл мэндийг дэмжих төвийн дэлгэцүүд дээр "Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйн эрх, үүрэг"-ийг гаргаж таниулж байна.<br><br>Амбулаторийн засвар үйлчилгээ бүрэн дуусч нүүлгэн шилжүүлэлт хийгдсэний |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7 | Байгууллага доторх мэдээллийн дэлгэц самбаруудыг эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн үүргийг таниулан сурталчлах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ Мэдээлэл технологийн алба | Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх таниулан сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулсан байна | дараа амбулаторийн тасагт хөлтэй анонсуудыг байршуулахаар ажиллаж байна.<br>Хөлтэй анонс хийлгэх хөлсийг эмнэлгийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос хариуцаж байна. |
| **II. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа хандлагыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, судалгаа явуулах, ажил зохион байгуулах** | | | | | | | | | |
| 2.1 | Ёс зүйн болон анагаах ухааны эрхзүй, үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулах | + | + | + | + | ЁЗСХ | УНТЭ-ийн ҮЭ-ийн хороо<br>Сургагч багш нар | Байгууллагын соёл сайжирсан байна. Үйлчилгээний стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлсэн байна.<br>Ажилтны сэтгэл ханамж нэмэгдсэн байна.<br>Ёсзүйн хэм хэмжээтэй холбогдох гомдол буурсан байна | Ёс зүй, харилцаа, хандлага, хөдөлмөрийн сахилга бат, манлайллын чиглэлээр хийсэн сургалтын дэлгэрэнгүй тайланг хавсралт №1-ээс харна уу.<br><br>Мөн сургалтын тайланг байгууллагын Улсын нэгдүгээр төв эмнэлгийн гадаад сайт – Ил тод булан – Ёсзүйн салбар хороо цэсэнд байршуулсан тул уншиж танилцана уу.<br>http://unte.moh.gov.mn/ |
| 2.2 | Ёс зүйн хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтад хамрагдах | + | + | + | + | ЁЗСХ | ЁЗСХ-ны дарга, нарийн бичгийн дарга | ЁЗСХ-ны гишүүдийн мэдлэг, ур чадвар чадавхи сайжирсан байна. | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хяналтын хорооноос хорооны гишүүдийг чадавхижуулах чиглэлд сургалт авах хүсэлтийг хүргүүлсэн. 2025 оны 6-р сард сургалтыг авахаар төлөвлөсөн. |
| 2.3 | Ёс зүйн сургагч багш нарыг бэлтгэх | + | + | + | + | ЁЗСХ сургалтын баг | ЭМЯ, ЭМХТ, АШУҮИС, бусад ТББ | Тасаг, нэгж бүрт 1 сургагч багш бэлтгэгдсэн байна. | Эрүүл мэндийн яам нь Зэлэм тархи ТББ-тай хамтран Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 2025.05.08-2025.07.17-ны өдрийн хугацаанд 15 сэдвийн дагуу 7 нэгжийн 51 ажилтанд “Харилцаа хандлага, ёс зүй, зөөлөн ур чадвар болон Багаар ажиллах чадварын сургалт”-ыг зохион байгуулж байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | <br>Сургалтын дэлгэрэнгүйг хавсралт №2-оос харна уу. |
| 2.4 | Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчид зориулсан сургалтыг НЭМА болон нэгжүүдтэй хамтран зохион байгуулах | + | + | + | + | ЁЗСХ сургалтын баг | УНТЭ, НЭМА, нэгжүүд | Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна | УНТЭ нь arslan.mn-тэй хамтран контент бүтээн ажилладаг бөгөөд эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 8 ярилцлага бэлтгэж, УНТЭ албан ёсны цахим хуудаст мэдээ мэдээлэл түгээхээс гадна Амбулатори болон Эрүүл мэндийг дэмжих төвийн дэлгэцээр эрүүл мэндийн боловсрол олгох контент, мэдээллийг цаг тухай бүрд шинэчлэн боловсруулж үйлчлүүлэгч нарт тогтмол түгээн ажиллаж байна.<br><br>УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба нь Дэлхийн эрүүл мэндийн тэмдэглэлт 8 өдрүүдийг тасаг, нэгжүүдтэй хамтран хуваарийн дагуу зохион байгуулж өдөрлөгт нийт 800 гаруй үйлчлүүлэгч хамрагдан 600 тараах материалыг тарааж мэдээлэл түгээсэн. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | Байгууллагын соёл, үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг авах, тайлагнах | + | + | + | + | ЁЗСХ судалгаа хариуцсан баг | УНТЭ Дотоод хяналтын мэргэжилтэн | Судалгааны үр дүнг эмнэлгийн удирдлага, дотоод хяналтын мэргэжилтэнд тайлагнаж ажилласан байна. | Журмын дагуу хагас болон бүтэн жилээр сэтгэл ханамжийн судалгааг авахаар төлөвлөн ажиллаж байна. |
| **III. Ёс зүйн салбар хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бусад** | | | | | | | | | |
| 3.1 | Иргэн, үйлчлүүлэгч, ажилтнаас хороонд ирүүлсэн өргөдөл гомдлыг зохих журмын дагуу хүлээн авч, хэлэлцэн, шийдвэрлэж ажиллах | + | + | + | + | ЁСЗХ | УНТЭ ЭМТҮ-ний Чанар, аюулгүй байдлын алба<br><br>Захиргаа, хүний нөөцийн алба | Хурлын тэмдэглэл, тайлан | Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороонд 2025 оны 5 сарын 30-ны дотор байдлаар нийт 9 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Журмын дагуу шийдвэрлэн ажиллаж байна.<br><br>Өргөдөл, гомдлын дэлгэрэнгүйг тайлангаас харна уу. |
| 3.2 | Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах | + | + | + | + | ЁЗСХ нарийн бичгийн дарга | ЁЗСХ, ЗАА-ны олон нийттэй харилцах мэргэжилтэн | Байгууллагын гадаад сайтны – ил тод булан – Ёсзүйн хороо дэд цэсэнд төлөвлөгөө, тайланг тухай бүрт мэдээллэж ажилласан байна | Эмнэлгийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны төлөвлөгөө, тайлангуудыг байгууллагын Улсын нэгдүгээр төв эмнэлгийн гадаад сайт – Ил тод булан – Ёсзүйн салбар хороо цэсэнд байршуулсан тул уншиж танилцана уу. |
| 3.3 | Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэх | | + | | + | ЁЗСХ дарга, нарийн бичгийн дарга | | Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 2 удаа хэлэлцэгдсэн байна. | 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Эмнэлгийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны хуралдаанаар эхний 5 сарын ажлын төлөвлөгөө, тайланг хэлэлцэж дүгнэсэн болно. |
| 3.4 | Ёс зүйн салбар хорооны самбарыг тухай бүрт мэдээллээр баяжуулах | + | + | + | + | ЁЗСХ нарийн бичгийн дарга | ЁЗСХ, ЭБАТ | Ил тод байдал хангагдсан байна | УНТЭ-т ашиглагдаж буй нийтийн эзэмшлийн талбайд байршилтай мэдээллийн 15 самбар, мэдээллийн 6 дэлгэцээр байгууллагаар үйлчлүүлэгчийн ёсзүйн хэм хэмжээг таниулан сурталчилж байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | <br>Зураг. Амбулаторийн мэдээллийн самбарны зураг<br><br><br><br><br>Зураг. Өргөтгөлийн байрны болон төв байрны мэдээллийн том самбаруудын зураг |
| 3.5 | Ёс зүйн салбар хорооны гишүүдийн цалин, урамшууллыг ажлын үр дүнд тулгуурлан олгох | + | + | + | + | ЁЗСХ хорооны дарга | УНТЭ Захиргаа | ЁЗСХ-ны үйл ажиллагаа тогтворжиж, гишүүдийн идэвх нэмэгдэнэ | Эрүүл мэндийн сайдын А/256 тушаалын дагуу эмнэлгийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооны гишүүдэд 2025 оны Б/114, Б/153 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тушаалуудаар 2 удаа урамшууллыг олгосон болно.<br><br>Зураг. 2025 оны Б/114, Б/153 тушаалын нүүр<br><br>Тушаалуудыг хавсралт №3-аас үзнэ үү. |
| 3.6 | Ёс зүйн салбар хорооны албан бичиг хэргийн хөтлөлт, хурлын тэмдэглэл болон өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийг хяналт тавин хэрэгжүүлж ажиллах | + | + | + | + | ЁЗСХ нарийн бичгийн дарга | ЁЗСХ | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, бичиг баримтын бүрдэлт эмх цэгц хангагдана | Салбар хорооны нарийн бичгийн дарга О.Лхагвасүрэн нь албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу тус хороонд ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, хурлын тэмдэглэлийг хөтөлж хэрэгжилтэд хяналт тавин хэрэгжүүлж ажиллаж байна. |
| 3.7 | Мэргэжлийн зэргийн шалгалтанд орох эмнэлгийн мэргэжилтэнд хорооноос тодорхойлолт бичиг гаргаж өгөх эсэх асуудлыг шийдвэрлэн ажиллах | | + | + | + | ЁЗСХ дарга, нарийн бичгийн дарга | ЁЗСХ | Ажилчдын хүсэлтийн дагуу тодорхойлолтыг цаг хугацаанд нь гаргаж өгөх | 2025 оны эхний 5 сард 9 ажилтанд тодорхойлолтыг боловсруулан өгч ажилласан. |
| 3.8 | ЁЗСХ-ны бүрэлдэхүүн бусад ЁЗСХ-ны үйл ажиллагаа, ажилтай танилцах, харилцан туршлага солилцох, Мөн Ёсзүйн хяналтын хорооны бүрэлдэхүүнтэй | + | | + | | ЁЗСХ-ны бүрэлдэхүүн | ЁЗСХ | Сайн ажиллаж байгаа ЁЗСХ-ны сайн туршлагыг нэвтрүүлэх | 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Монголын сувилагчдын нийгэмлэг, Эрүүл мэндийн яамтай хамтран зохион байгуулсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба үнэ цэнэ” сэдэвт 2 багц цагийн олон улсын сургалтад тус эмнэлгээс 5 ажилтанг хамруулсан. Үүнд: |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | уулзаж зөвлөгөө, мэдээлэл авах | | | | | | | - Сувилахуйн албаны арга зүйч Д.Долгор<br>- Эрчимт эмчилгээний тасгийн сувилагч Б.Гулжан<br>- Эрчимт эмчилгээний тасгийн сувилагч С.Түмэндэмбэрэл<br>- Яаралтай тусламжийн тасгийн сувилагч Г.Гэрэлсайхан<br>- Яаралтай тусламжийн тасгийн сувилагч Г.Анзаяа нарыг хамруулсан.<br><br>Зураг. Сургалтад оролцогчдын нэрс |
| 3.9 | Ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллахад шаардлагатай бичиг хэргийн зардал | + | + | + | + | ЁЗСХ дарга, нарийн бичгийн дарга | ЁЗСХ | Ёсзүйн салбар хорооны хэвийн үйл ажиллагаа хангагдана. | Албан ажлын хэрэгцээнд шаардлагатай бичиг хэргийн материалыг Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албанаас гаргуулан ажиллаж байна. |

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянасан: УНТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн салбар хорооны дарга Б.Ганзориг

Төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэсэн: УНТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн салбар хорооны нарийн бичгийн дарга

О.Лхагвасүрэн